**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЖ БУЙ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН БИЕЛЭЛТ**

2017.06.20

| № | Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл | Арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Улсын 2017 онд хүрэх түвшин, үр дүн | 2017 онд шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /тэрбум төгрөг/ | Хүрсэн түвшин, хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **ГУРАВ. БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО** | | | | | | | |
| **Зорилт 8. Хүн амын нутагшилт, суурьшил, бүс нутгийн зохистой тогтолцоонд тулгуурлан хот, суурин газрыг хөгжүүлж, хүн амын ая тухтай амьдрах орчныг бүрдүүлнэ** | | | | | | | |
| 1 | 8.1 МУТХҮБ-ын 2.1.5, Зорилт 6, ЗГҮАХ-ийн 2.77, 3.4.3 дахь заалт | Хүн амын орон сууцны хэрэгцээг хангах хүрээнд эрх зүйн орчныг сайжруулж, төсөл хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэх | “Түрээсийн орон сууц” хөтөлбөрт шинээр хамрагдах өрхийн тоо | 1000 | | 2017 оны хагас жилийн байдлаар Түрээсийн орон сууцны төслийн хүрээнд баригдаж байгаа орон сууц байхгүй байна. | ҮБ |
| 2 | 8.2 МУТХҮБ-ын 2.1.5, Зорилт 5, 6, ЗГҮАХ-ийн 2.81, 2.85 дахь заалт | Газрын нэгдсэн бодлогын хүрээнд газар ашиглах, эзэмших, өмчлөх эрх зүйн зохицуулалтыг сайжруулж, геодезийн нэгдсэн тогтолцоог өргөжүүлэх | Геодезийн нэгдсэн тогтолцоог өргөжүүлэх ажлын явц, хувиар | 30-аас доошгүй | 2.1 Улсын төсөв | Манай аймгийн гүйцэтгэгч “Экситос” ХХК нь 2017 оны 03 дугаар сард зөрүүтэй мэдээллүүдийг цаасан хэлбэрээр ирүүлсэн бөгөөд 3 сумын газрын даамлууд тулгалт хийж байна.<br>2014 оны 08 дугаар сар хүртэлх хувийн хэргүүдийг цахимжуулан мэдээллийн санд оруулж, газрын кадастрын нэгдсэн тогтолцоонд /WGS-84/ шилжүүлэх ажил хийгдэж лэнд менежер программ хангамжийг | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аймгийн хэмжээнд ашиглаж эхлээд байна. | |
| 3 | 8.5 МУТХҮБ-ын 2.1.5, Зорилт 5, 6, ЗГҮАХ-ийн 2.91 дэх заалт | Улаанбаатар хот болон аймгуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан цэвэрлэх байгууламжуудыг шинэчлэх | Шинээр барих цэвэрлэх байгууламжий н тоо | 6 | 8.2 Гадаад Эх үүсвэр, 8.7 Хөгжлийн банк | Аймгийн төвд цэвэрлэх байгууламж барих ажлын зураг төсвийн ажлыг Наран рашаан ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд Барилга, хот байгуулалтын сайдаас Сангийн яам болон Гадаад харилцааны яаманд Польш болон Унгар улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хүсэлтийг хүргүүлээд байна. | ҮБ |
| 4 | 8.6 МУТХҮБ-ын 2.1.5, Зорилт 5, 6, ЗГҮАХ-ийн 2.103 дахь заалт | Сумын төвийн дэд бүтцийг сайжруулах ажлыг үргэлжлүүлэх | Дэд бүтцийг сайжруулах ажлын явц, хувиар | 30.0 | 6.1 Хөгжлийн банк | Сумын төвийн дэд бүтцийг сайжруулах төслийн хүрээнд Хөгжлийн банкны 40 сая төгрөгийн санхүүжилтээр Сүмбэр сумын 1, 2 дугаар багийн гэр хорооллын айл өрхийг цэвэр усны шугамд холбох ажлын зураг төсвийг боловсруулах ажлын тендер шалгаруулалтыг зарлаад байна. | 40 |
| **Зорилт 9. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын эрхзүйн орчныг сайжруулж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.** | | | | | | | |
| 5 | 9.4 МУТХҮБ-ын 2.3.1, Зорилт 1, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 4.2.3, 4.2.4 дэх заалт | Гидрогеологийн хайгуулын судалгаа хийж, бороо, цасны усыг хуримтлуулах хөв, цөөрөм байгуулах, булаг шандны эхийг хашиж хамгаалах ажлыг үргэлжлүүлэх | Хамгаалалт хийх булаг шандны тоо | 100-гаас доошгүй | 1.0 Орон Нутгийн төсөв | Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 7.0 сая төгрөгөөр Шивээговь суманд Бэхтийн булаг, Сүмбэр суманд Өгөөмөрийн голыг хашиж хамгаалах ажлыг гүйцэтгэгчээр Өөдлөх Өгөөмөр иргэдийн бүлгийг шалгаруулан ажлыг эхлүүлсэн. | 70 |
| 6 | 9.5 МУТХҮБ-ын 2.3.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 4.1.6 | Түүхий нүүрсний хэрэглээг бууруулах, сэргээгдэх эрчим хүч, цэвэр түлшний | Цахилгааны урамшуулал болон хөнгөлөлттэй | 40,000-аас доошгүй | 5.0 Улсын төсөв | Цахилгааны суурь үнэ 0-50 квт 98,40 төгрөг, 150-с дээш квт нь 118,20 төгрөг байдаг. Аймгийн хэмжээнд эмзэг бүлгийн 24 хэрэглэгч 0-50 квтыг | 40 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дахь дэд заалт | хэрэглээг нэмэгдүүлэх замаар агаарын чанарыг сайжруулах | үнээр сайжруулсан түлш авах өрхийн тоо | | | 48,3 төгрөг, 51-с дээш квтыг 69,3 төгрөгийн хөнгөлөлттэй үнээр цахилгаан хэрэглэж байна. | |
| 7 | 9.6 МУТХҮБ-ын 2.3.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 4.2.7 дахь дэд заалт | Ойг хамгаалах, ойжуулах, нөхөн сэргээх ажлыг чанаржуулж, хүлэмжийн хийн шингээх чадварыг нэмэгдүүлэх | Ойн цэвэрлэгээ хийх талбайн хэмжээ, мян.га | 34 | 4.5 Улсын болон орон нутгийн төсөв | “Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийн хүрээнд улсын төсвөөс 10 сая төгрөгөөр 5 га талбайд ойн зурвас байгуулахаар төлөвлөн улсын чанартай автозамын дагуу 5 га талбайд 3100 мод бут тарьж, Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 8.0 сая төгрөгөөр хашаажуулсан.<br>Сум дундын ойн ангийн Мод үржүүлгийн газрын бойжуулалтын талбайд 5 төрлийн 15850 мод бутыг шилжүүлэн суулгаж, хүлэмжид 2 төрлийн бургас 860 ширхэг, үрээр 4 төрлийн мод бутны 4.65 кг үрийг үржүүлж байна. | 70 |
| **ДӨРӨВ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ НИЙГМИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| **Зорилт 11. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын эрх зүйн орчныг сайжруулж, боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, ая тухтай сурч, боловсрох орчныг бүрдүүлэх бодлого хэрэгжүүлнэ** | | | | | | | |
| 8 | 11.1 МУТХҮБ-ын 2.2.3,<br>Зорилт 1, ЗГҮАХ-ийн 3.2.2, 3.2.5 дахь дэд заалт | “Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөрийг хэрэгжүүлж, сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтын хувийг нэмэгдүүлэх | Хамран сургалтын бохир жин, хувиар | | Улсын төсөв | Хамран сургах тойргийн 1842 хүүхдийн 1768 хүүхдийг үндсэн сургалтанд, 94 хүүхдийг хувилбарт сургалтанд хамруулж, хамран сургалтын бохир жин 100 хувьд хүрсэн. | 40 |
| | | | Ашиглалтад оруулах цэцэрлэгийн тоо | | Улсын төсөв<br>Гадаад эх үүсвэр | Сүмбэр сумын 100 хүүхдийн Канад загварын цэцэрлэгийн барилгын ажил 2013 оны 05 дугаар сараас эхэлсэн бөгөөд барилгын ажил гүйцэтгэл 65 хувьтай гүйцэтгэгдсэн байна. Барилгын ажлыг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үргэлжлүүлэн барих хөрөнгө шийдвэрлэгдээгүй тул 2017 онд барилга угсралтын ажил хийгдээгүй байна. | |
| | | | Шинээр байгуулах байгууллагын цэцэрлэгийн тоо | | Улсын төсөв, Гадаад эх үүсвэр | Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэгийн 150 хүүхдийн өргөтгөлийн барилгыг шинээр барихаар төлөвлөсөн боловч санхүүжилт шийдвэрлэгдээгүй байна. | |
| 9 | 11.2 МУТХҮБ-ын 2.2.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 3.2.3, 3.2.6 дахь дэд заалт | Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны хүртээмж, орчин нөхцөлийг сайжруулан хүүхдийн ая тухтай сурч, хүмүүжих орчныг бүрдүүлэх | Шинээр ашиглалтад оруулах сургуулийн тоо | | 24.0 Улсын төсөв | Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн барилгын зураг төсөв боловсруулах ажил хийгдэж байгаа бөгөөд сургуулийн барилгын санхүүжилт шийдвэрлэгдээгүй байна.<br>Баянтал сумын 4-р сургуулийн дотуур байрны засварын ажил Харвайн толгой ХХК 49,862.0 төгрөгөөр гүйцэтгэж ашиглалтад оруулсан.<br>Шивээговь сумын 3-р сургуулийн дээврийн засварын ажлыг Улсын төсвийн 107.0 сая төгрөгөөр гүйцэтгүүлэхээр тендер шалгаруулалтыг зарласан бөгөөд тендерийг 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдөр нээнэ.<br>Аймгийн хэмжээний 5 ерөнхий боловсролын сургуулиас 4 нь дотуур байртай үйл ажиллагаа явуулж байна. Дотуур байрны хүртээмж, орчин нөхцлийг сайжруулан хүүхдийн ая тухтай сурч, хүмүүжих орчныг бүрдүүлэх зорилгоор Япон улсын Өвсний үндэс хөтөлбөрийн 168.0 сая төгрөгөөр Сүмбэр сумын 5 дугаар | 70 |
| | | | Орчин нөхцөлийг сайжруулах дотуур байрны тоо | 10 | 1.2 Улсын төсөв | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургуулийн дотуур байрны гадна фасад, дотор засварын ажлыг Гээт ХХК-аар, 2016-2017 оны АОНХСангийн 116.5 сая төгрөгөөр дотуур байрны гадна тохижилтын ажлыг Илчит сансар ХХК-аар тус тус гүйцэтгүүлэн, улсын комисс хүлээн авсан. | |
| **Зорилт 13. Хүн амд чанартай, тэгш, хүртээмжтэй эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүргэж, эх орондоо оношлуулах, эмчлүүлэх боломжийг нэмэгдүүлнэ** | | | | | | | |
| 10 | 13.1 МУТХҮБ-ын 2.2.2,<br><br>Зорилт 2, ЗГҮАХ-ийн 3.1.7 дахь дэд заалт | Эх, хүүхдийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эх, нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах | 100,000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн түвшин, промиль | 27.9 | | Манай аймаг сүүлийн 10 жил эхийн эндэгдэл гаргалгүй ажиллаж байна. | 70 |
| | | | 1000 амьд төрөлтөд нялхсын эндэгдлийн түвшин, промиль | 14.0 | | Эхний хагас жилийн байдлаар төрөлт-156, амьд төрсөн хүүхэд-157, нялхсын эндэгдэл-1, 1000 амьд төрөлтөд 6.3 промилл, өнгөрсөн оны суурь түвшинтэй харьцуулахад 9.3 промиллээр буурсан үзүүлэлттэй байна. | |
| | | | 1000 амьд төрөлтөд 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин, промиль | 16.7 | | 0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 4 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 19.1 промилл буюу өмнөх оны суурь түвшинтэй харьцуулахад 0.9 промиллээр буурсан үзүүлэлттэй байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | 13.2 МУТХҮБ-ын 2.2.2,<br><br>Зорилт 4,ЗГҮАХ-ийн 3.1.3 дахь дэд заалт | Элэгний вируст хепатитийн халдварыг эрт илрүүлэх үзлэг, шинжилгээнд хүн амыг хамруулж, эмчилгээг эрчимжүүлэх | Оношлогоонд хамрагдах иргэдийн эзлэх хувь | 100.0 | 18.5<br>Улсын төсөв | Засгийн газрын 2017 оны 04 дүгээр сарын 12-ны 112 дугаар тогтоол “Элэг бүтэн монгол үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд 40-65 насны хепатитийн В,С вирусийн эрт илрүүлэг, үзлэг шинжилгээнд 3906 иргэнийг хамруулахаар төлөвлөн ажиллаж байна. В,С вирусын эрт илрүүлгийн санхүүжилт 2-р улиралд шийдвэрлэгдсэнтэй холбогдуулан 2017 оны 05 дугаар сараас эрт илрүүлэг, үзлэг шинжилгээ эхэлж, 2017 оны 06 дугаар сарын байдлаар 2785 иргэн буюу 71 хувь нь хамрагдсанаас В-174, С-131 нийт 305 вирус илрээд байна. Үүнээс вирусын идэвхжлээ тоолуулж эмчилгээ эхэлсэн В-10, С-47 нийт 57 иргэн эмчлүүлж байна. | 70 |
| 12 | 13.6 МУТХҮБ-ын 2.2.2,<br><br>Зорилт 1,ЗГҮАХ-ийн 4.1.16 дахь дэд заалт | Эмнэлгийн аюултай хог хаягдлын менежментийг сайжруулах хүрээнд бүсийн оношлогоо эмчилгээний төв болон аймгийн нэгдсэн эмнэлгийн дэргэд хог хаягдлыг түр хадгалах байгууламжийг барих | Шинээр байгуулах байгууламжий н тоо | | 2.5<br>Улсын төсөв<br>7.0<br>Гадаад эх үүсвэр | Аймгийн Нэгдсэн эмнэлэг өөрийн нөхцөл байдалд тохируулан хог хаягдлыг түр хадгалах байртай болсон. Хаягдлыг төвлөрүүлэх цэг аймгийн хэрэгцээг бүрэн хангаж байна. | 100 |
| 13 | 13.9 ЗГҮАХ-ийн 3.1.2 дахь дэд заалт | Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношлогоо, шинжилгээнд үе шаттайгаар хамруулах | Шинжилгээнд хамрагдах хүний тоо | | 10.2 Улсын төсөв | Оны эхний 4 сарын байдлаар 2 байгууллагын 72 ажилтныг үзлэгт хамруулж, зөвлөгөө өгөх, эмчлэн эрүүлжүүлэх ажил хийгдэж байна.<br>“Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хепатитийн | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | вирусийн эсрэг эмчилгээнд шаардлагатай эмийн хөнгөлөлтийг эрүүл мэндийн даатгалын сангаас үзүүлэх, 40-65 насны бүртгэгдсэн 3906 хүн амыг хуваарийн дагуу үзлэг, шинжилгээнд хамруулах үе шаттай ажлуудыг зохион байгуулж эхэлж одоогоор 2785 иргэн буюу 71 хувийн хамралттай байна. 2017 оны 6 дугаар сарын байдлаар даатгуулагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлын хүрээнд байгууллага, иргэн нийт 2857 иргэнийг хамруулсан байна. | |
| 14 | 13.11 МУТХҮБ-ын 2.2.2,<br>Зорилт 1,<br>ЗГҮАХ-ийн 3.1.10 дахь дэд заалт | Багийн эмч болон хотын алслагдсан хороодын өрхийн эрүүл мэндийн төвийг унаагаар хангах хөтөлбөр хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | | | Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд сумдын ОНХС-ын 60.0 сая төгрөгөөр Сүмбэр, Шивээговь сумдын эрүүл мэндийн төвийг түргэн тусламжийн автомашинаар хангахаар туссан. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Шивээговь сумын эрүүл мэндийн төвд Улсын онцгой комисс 30,0 сая төгрөгийн пургон автомашин, аймгийн Нэгдсэн эмнэлэгт Эрүүл мэндийн сайдаас 30,0 сая төгрөгийн пургон автомашинаар хангасан. Түргэн тусламжийн машинаар хөдөөгийн багийн хүн амд явуулын үйлчилгээ үзүүлж байна. | 100 |
| **Зорилт 14.Гэр бүл, хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийг дэмжих бодлого явуулж, эрх зүйн орчныг сайжруулна** | | | | | | | |
| 15 | 14.5 МУТХҮБ-ын 2.2.1, | Бичил аж ахуйн нэгж, иргэдийн хөдөлмөр | Хөдөлмөр эрхлэлтийг | | | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 6 хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн | 40 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Зорилт 2, ЗГҮАХ-ийн 1.17 дахь заалт | эрхлэлтийг зээлийн бодлогоор дэмжих | дэмжих сангаас зээл авах бичил аж ахуйн нэгж, иргэдийн тоо | 6000 | 20.0<br><br>Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан /цаашид “ХЭДС” гэх/ | дэмжлэг үзүүлэх 24 төсөл сонгон шалгаруулж, 76500.0 мян төгрөгийн дэмжлэгийг олгох төсөв батлагдсан. Арга хэмжээнд хамрагдахаар зорилтод бүлгийн нийт 56 иргэн төсөл ирүүлж 187373.0 мянган төгрөгийн дэмжлэг хүсээд байна. | |
| | | | Шинээр бий болох ажлын байрны тоо | 10,000 | | Хөдөлмөр эрхлэлтийн Үндэсний зөвлөлийн 2017 оны 03 дугаар тогтоолын дагуу “Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот 3 төслийг аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлэв. Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр хэрэгжих хөтөлбөрийн арга хэмжээг эхлүүлэн хэрэгжүүлж байна. | |
| 16 | 14.6 МУТХҮБ-ын 2.2.1, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 3.3.4 дэх дэд заалт | Хөдөлмөрийн зах зээлд эрэлт ихтэй мэргэжлийн ур чадварыг богино хугацаанд олгох хөдөлмөр эрхлэлтийн болон үйлдвэрлэл дээрх сургалтыг зохион байгуулах | Хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамрагдах хүний тоо | 5000 | 2.5<br>ХЭДС | Орон нутгийн хөдөлмөрийн зах зээлд эрэлттэй 10 ажлын байрны судалгааг гаргасан. Ажилгүй, ажил олоход хүндрэлтэй хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй иргэдээс мэргэжлийн сургалтад хамрагдах хүсэлтийг хүлээн авч байна. | 40 |
| | | | Үйлдвэрлэл дээрх сургалтад хамрагдах хүний тоо | | | Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөрийн үйлдвэрлэл дээрх сургалтад 6 иргэнийг хамруулж 4200.0 мян төгрөгийг зарцуулахаар төсөв батлагдсан. Одоогоор үйлдвэрлэл дээрх сургалт хамтран зохион байгуулах ажил олгогч, аж | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ахуйн нэгж, иргэнээс хүсэлт ирээгүй байна. Бүрэн Урлан ХХК-тай хамтран ажиллахаар судалгаа хийгдэж байна. | |
| 17 | 14.10 МУТХҮБ-ын 2.2.3,<br>Зорилт 1 | Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн дагуу хүүхэд харах үйлчилгээг үргэлжлүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | 5.8<br>Улсын төсөв | Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулж аймгийн хэмжээнд 2 иргэн хүүхэд харах үйлчилгээ тогтмол явуулж байна. Үүнд: Шивээговь сумын 21-р зөрлөгт “Солонго” хүүхэд харах үйлчилгээ 10 хүүхэд, Сүмбэр сумын 2-р багийн Төгрөгийн 2-14 тоотод “Билгүүн” хүүхэд харах үйлчилгээнд 5 хүүхэд хамрагдаж байна. Хүүхэд харах үйлчилгээг эрхлэн явуулснаар 3 иргэн ажлын байраар хангагдсан. Хагас жилийн байдлаар 8022,4 мянган төгрөгийн санхүүжилтийг Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас олгоод байна. | 70 |
| 18 | 15.3 МУТХҮБ-ын 2.4,<br>Зорилт 1, 2,<br>ЗГҮАХ-ийн 5.2.8 дахь дэд заалт | Улсын бүртгэлийн ажиллагааг онлайн горимд шилжүүлж, “Нэг иргэн-нэг бүртгэл” хөтөлбөр хэрэгжүүлэх замаар бүртгэлийн тогтолцоог үе шаттай төгөлдөржүүлэх | Гадаад паспортын үйлчилгээнд цахим олголтын программыг нэвтрүүлэх ажлын явц, хувиар | 60.0 | | Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газраас иргэдэд тоон гарын үсэг олгох, гадаад паспортын үйлчилгээнд цахим олголтыг нэвтрүүлэх ажил өнөөдрийн байдлаар бэлтгэл ажлын шатандаа явж байгаа бөгөөд программ хангамжийг шийдвэрлэхээр хүлээгдэж байна. | ҮБ |
| | | | Иргэдэд тоон гарын үсэг олгох бэлтгэл ажлын явц, хувиар | 100.0 | | | |
| 19 | 15.6 МУТХҮБ-ын 2.2.1, | Аж ахуйн нэгжтэй хамтарсан оёдлын | Ялтныг ажлын | 59.0 | | 2016-2017 оны хичээлийн жилд хамтран ажиллах гэрээний дагуу | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Зорилт 2, ЗГҮАХ-ийн 5.4.10 дахь дэд заалт | болон шохойн чулууны үйлдвэрлэлийг өргөтгөж, ялтныг ажлын байраар хангах | байраар хангах хувь | | - | ялтанд мэргэжил эзэмшүүлэх хөдөлмөрийн дадлага олгох сургалтыг аймгийн Уул уурхайн жишиг сургууль Политехникийн коллежтэй хамтран “Уул уурхайн хүнд машин механизмын опператорчин”, “Барилгын цахилгаанчин”, “Нөхөн сэргээлт” зэрэг мэргэжлээр 45 ялтныг мэргэжил олгох сургалтад хамруулсан. Мөн ялтныг ажлын байраар хангах чиглэлээр даалингийн сургалтад хамруулж 20 ялтныг, аймгийн Сум дундын ойн ангитай гэрээ байгуулан 20 ялтныг, гутлын цехэд 3 ялтан, мужааны цехэд 7 ялтан, чулууны цехэд 5 ялтан, аж ахуйн үйлчилгээнд 97 ялтан, нийт 152 буюу хорих 0425 дугаар ангид ял эдэлж буй нийт ялтны 60 хувийг ажлын байраар ханган ажиллуулж байна. | |

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН 2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО**

| д/д | Зорилтын тоо | Арга хэмжээний тоо | Хэрэгжилтийн үнэлгээ | | | | Үнэлэх боломжгүй | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100% | 70% | 40% | 0% | | |
| 1 | 19 | 19 | 3 | 8 | 5 | - | 3 | **66.3** |

ТАЙЛАН ХЯНАСАН: АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Д.СОДНОМ

ТАЙЛАН ГАРГАСАН: ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Х.БУЯНБАЯР

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН 2017 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТИЙН ТОВЧОО**

| д/д | Зорилтын дугаар | Арга хэмжээний тоо | Хэрэгжилтийн үнэлгээ | | | | Үнэлэх боломжгүй | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100% | 70% | 40% | 0% | | |
| 1 | 1 | 1 | | | | | 1 | |
| 2 | 2 | 1 | | 1 | | | | |
| 3 | 3 | 1 | | | | | 1 | |
| 4 | 4 | 1 | | | 1 | | | |
| 5 | 5 | 1 | | | | | | |
| 6 | 6 | 1 | | | 1 | | | |
| 7 | 7 | 1 | | 1 | | | | |
| 8 | 8 | 1 | | | 1 | | | |
| 9 | 9 | 1 | | 1 | | | | |
| 10 | 10 | 1 | | 1 | | | | |
| 11 | 11 | 1 | | 1 | | | | |
| 12 | 12 | 1 | 1 | | | | | |
| 13 | 13 | 1 | | 1 | | | | |
| 14 | 14 | 1 | 1 | | | | | |
| 15 | 15 | 1 | | | 1 | | | |
| 16 | 16 | 1 | | | 1 | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | 17 | 1 | | 1 | | | | |
| 18 | 18 | 1 | | | | | 1 | |
| 19 | 19 | 1 | 1 | | | | | |
| Нийт | 19 | 19 | 3 | 8 | 5 | - | 3 | **66,3** |

ТАЙЛАН ХЯНАСАН: ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА ..... Д.СОДНОМ

ТАЙЛАН ХЯНАСАН: ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД
АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА ..... Х.БУЯНБАЯР